

ГОВЬ-АЛТАЙ АЙМАГ ДАХЬ ТӨРИЙН АУДИТЫН ГАЗАР



САНХҮҮГИЙН ТАЙЛАНГИЙН АУДИТ

Говь-Алтай аймгийн Эрдэнэ сумын Эрүүл мэндийн төвийн 2021 оны санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлд хийсэн санхүүгийн тайлангийн аудитын тайлан

Аудитын код: ГАА-2022/45/-НА-СТА-ТШЗ

Цахим хуудас: www.audit.mn Алтай хот 2022 он	Дарга, Тэргүүлэх аудитор: Х.Түвшинбаяр Утас: 70483413 Аудитын менежер: Д.Эрдэнэчимэг Утас: 70484055 Ахлах аудитор: Ж.Бүжинханд Утас: 99177546 Аудитор: Б.Цэвэлмаа Утас: 99026016	Цахим хаяг: tuvshinbayarkh@audit.gov.mn Цахим хаяг: erdenechimegd@audit.gov.mn Цахим хаяг: Vujinkhandj@audit.gov.mn Цахим хаяг: Tsevelmaab@audit.gov.mn
---	---	--

Энэхүү аудитын тайлантай холбоотой нэмэлт мэдээллийг дээрх хаягаар авна уу.

Агуулга

2.Аудит хийсэн санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэл	4
2.1 Аудит хийсэн санхүүгийн байдлын тайлан	4
2.2 Аудит хийсэн санхүүгийн үр дүнгийн тайлан	5
2.3 Аудит хийсэн цэвэр хөрөнгө/өмчийн өөрчлөлтийн тайлан	7
2.4 Аудит хийсэн мөнгөн гүйлгээний тайлан.....	7
2.5 Аудит хийсэн төсвийн гүйцэтгэлийн тайлан.....	9
2.6 Аудит хийсэн нэмэлт төсвийн гүйцэтгэлийн тайлан.....	10
3. Аудитын тайлан	12
3.1 Ерөнхий зүйл	12
3.2 Байгууллага, түүний орчин ба дотоод хяналт	12
3.3 Санхүүгийн тайлагналын үзэл баримтлал.....	12
3.4 Материаллаг байдал	13
3.5 Санхүүгийн тайлангийн тодруулга	13
3.6 Төсвийн төлөвлөлт, гүйцэтгэл, нэмэлт төсөв	13
3.7 Асуудлыг онцолсон хэсэг ба бусад асуудлын хэсэг.....	15
3.8 Аудитын гол асуудал	15
3.9 Санхүүгийн тайлангийн аудитаар шалгасан нийцлийн аудитын асуудал	15
3.9.1 Шилэн дансны тухай хуулийн хэрэгжилт	15
3.10 Өмнөх зөвлөмжийн хэрэгжилт.....	15
3.11 Дараагийн аудитаар анхаарах асуудал.....	15
4. Аудитын илрүүлэлт	16
4.1 Залруулсан алдаа	16
4.2 Төлбөрийн акт.....	16
4.3 Албан шаардлага	16
4.4 Зөвлөмж.....	16
5. Аудитаар илэрсэн алдаа, зөрчлийн нэгтгэл	17

Товчилсон үгийн жагсаалт

УСНББОУС	Улсын Секторын Нягтлан Бодох Бүртгэлийн Олон Улсын Стандарт
АДБОУС	Аудитын Дээд Байгууллагын Олон Улсын Стандарт



ГОВЬ-АЛТАЙ АЙМАГ ДАХЬ ТӨРИЙН АУДИТЫН ГАЗАР

9018301, Говь-Алтай аймаг,
Есөнбулаг сум, 7-р баг, Жинст 0
Утас: 70-48-34-13. Факс: (976) 70-48-34-13,
E-mail: govialtai@audit.gov.mn

2022.02.25 № 87

танай _____ -ны № _____ -т

Зөрчилгүй дүгнэлт

Төрийн аудитын тухай хуулийн 6 дугаар зүйлийн 6.3.1, 8 дугаар зүйлийн 8.1, Төсвийн тухай хуулийн 8 дугаар зүйлийн 8.9.1-д заасны дагуу Говь-Алтай аймгийн Эрдэнэ сумын Эрүүл мэндийн төвийн 2021 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөрх санхүүгийн байдал, санхүүгийн үр дүн, цэвэр хөрөнгө/өмчийн өөрчлөлт, мөнгөн гүйлгээний тайлан, тодруулгууд болон төсвийн гүйцэтгэлд аудит хийлээ.

Говь-Алтай аймгийн Эрдэнэ сумын Эрүүл мэндийн төвийн 2021 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөрх санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлийг Төсвийн тухай хууль, Нягтлан бодох бүртгэлийн тухай хууль, Улсын секторын нягтлан бодох бүртгэлийн олон улсын стандартад нийцүүлэн бүх материаллаг зүйлсийн хувьд үнэн зөв толилуулсан байна.

Дүгнэлтийн үндэслэл

Төрийн аудитын байгууллага аудит хийхдээ Аудитын дээд байгууллагын олон улсын стандарт, түүнд нийцүүлэн Монгол Улсын Ерөнхий аудиторын баталсан журам, зааврын дагуу гүйцэтгэж, шалгагдагч этгээдээс хараат бус, аудиторын ёс зүйн үүрэг хариуцлагыг биелүүлж ажилласан. Бидний цуглуулсан хангалттай бөгөөд зохистой нотолгоо нь дүгнэлт өгөх үндэслэл болно.

Санхүүгийн тайланд төсвийн захирагчийн хүлээх үүрэг, хариуцлага

Төсвийн захирагч санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлийг Төсвийн тухай хууль, Нягтлан бодох бүртгэлийн тухай хууль, Улсын секторын нягтлан бодох бүртгэлийн олон улсын стандартын дагуу үнэн зөв бэлтгэж толилуулах үүрэгтэй.

Санхүүгийн тайланг залилан эсвэл алдааны улмаас үүсэх материаллаг буруу илэрхийлэлгүй бэлтгэхэд шаардлагатай гэж үзсэн дотоод хяналтыг тодорхойлж, хэрэгжүүлэх үүрэг хариуцлага хүлээнэ.

Төрийн аудитын байгууллагын үүрэг, хариуцлага

Төрийн аудитын байгууллага залилан эсвэл алдааны улмаас үүсэх материаллаг буруу илэрхийллээс санхүүгийн тайлан бүхэлдээ ангид эсэх талаарх үндэслэлтэй баталгаажуулалт олж авах, дүгнэлт, зөвлөмж бүхий аудитын тайлан гаргах зорилготой.

Үндэслэлтэй баталгаажуулалт гэдэг нь дээд түвшний баталгаа боловч материаллаг буруу илэрхийлэл байгаа тохиолдолд АДБОУС-ын дагуу хийсэн аудитаар бүгдийг илрүүлнэ гэсэн баталгаа биш юм.

Буруу илэрхийлэл нь залилан эсвэл алдаанаас үүсэж болох бөгөөд дангаараа эсвэл нийлээд уг санхүүгийн тайланд үндэслэн гаргах хэрэглэгчдийн эдийн засгийн шийдвэрт нөлөөлөх үндэслэлтэй байвал материаллаг гэж үздэг.

ДАРГА, ТЭРГҮҮЛЭХ АУДИТОР

Х.ТҮВШИНБАЯР

07020183

2. Аудит хийсэн санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэл

2.1 Аудит хийсэн санхүүгийн байдлын тайлан

Код	Үзүүлэлт	Эхний үлдэгдэл	Эцсийн үлдэгдэл
1	ЭРГЭЛТИЙН ХӨРӨНГИЙН ДҮН	25,514,502.89	161,712,669.87
31	МӨНГӨН ХӨРӨНГӨ	0.00	6,414,169.38
31200	Банкинд байгаа бэлэн мөнгө	0.00	6,414,169.38
31210	Төгрөг	0.00	6,414,169.38
31211	Төрийн сангийн харилцах	0.00	5,678,071.38
31215	Нэмэлт санхүүжилтийн харилцах	0.00	736,098.00
33	АВЛАГА	0.00	103,920,500.00
33200	Төлбөртэй үйлчилгээний авлага	0.00	103,866,500.00
33500	Бусад авлага	0.00	54,000.00
33510	Байгууллагаас авах авлага	0.00	54,000.00
35	БАРАА МАТЕРИАЛ	25,514,502.89	51,378,000.49
35100	Түүхий эд материал	10,046,786.31	28,164,463.91
35110	Тусгай зориулалттай материал	177,500.00	220,000.00
35130	Эм боох материал	9,869,286.31	27,944,463.91
35400	Хангамжийн материал	15,467,716.58	23,213,536.58
35410	Бичиг хэргийн материал	140,440.00	386,940.00
35420	Аж ахуйн материал	1,184,410.00	1,326,450.00
35440	Түлш, шатах тослох материал	1,702,750.00	5,822,000.00
35450	Барилгын засварын материал	187,650.00	1,695,300.00
35460	Хүнсний материал	1,030,520.00	845,700.00
35470	Бусад хангамжийн материал	11,221,946.58	13,137,146.58
2	ЭРГЭЛТИЙН БУС ХӨРӨНГИЙН ДҮН	604,686,182.31	563,807,611.69
39	ҮНДСЭН ХӨРӨНГӨ	604,686,182.31	563,807,611.69
39200	Биет хөрөнгө	592,604,682.31	551,801,111.69
39201	Барилга, байгууламж, орон сууц	371,083,203.28	373,083,203.28
39202	Хуримтлагдсан элэгдэл	-33,273,405.04	-44,694,287.19
39203	Авто-тээврийн хэрэгсэл	35,776,434.00	37,571,305.00
39204	Хуримтлагдсан элэгдэл	-22,636,253.26	-28,491,898.22
39205	Машин тоног төхөөрөмж(компьютер)	380,901,445.58	395,928,667.14
39206	Хуримтлагдсан элэгдэл	-148,921,233.58	-189,640,533.65
39207	Тавилга, аж ахуйн эд хогшил	13,163,160.00	13,163,160.00
39208	Хуримтлагдсан элэгдэл	-6,516,501.88	-8,335,567.04
39213	Түүх соёл, музейн дурсгалт зүйлс	450,000.00	450,000.00
39214	Бусад үндсэн хөрөнгө	3,890,000.00	4,500,000.00
39215	Хуримтлагдсан элэгдэл	-1,312,166.79	-1,732,937.63
39300	Биет бус хөрөнгө	12,081,500.00	12,006,500.00
39301	Програм хангамж	850,000.00	300,000.00
39302	Хуримтлагдсан элэгдэл	-662,500.00	-187,500.00
39303	Бусад биет бус хөрөнгө	11,894,000.00	11,894,000.00
3	НИЙТ ХӨРӨНГИЙН ДҮН III=I+II	630,200,685.20	725,520,281.56
4	НИЙТ ӨР ТӨЛБӨР	0.00	13,546,865.00
41	БОГИНО ХУГАЦААТ ӨР ТӨЛБӨР	0.00	13,546,865.00
41300	Өглөг	0.00	13,546,865.00
41320	Бараа үйлчилгээний зардлын өглөг	0.00	12,158,865.00
41360	Бусад өглөг	0.00	1,388,000.00
41361	Байгууллагад төлөх өглөг	0.00	1,388,000.00
5	ЦЭВЭР ХӨРӨНГӨ ӨМЧИЙН ДҮН	630,200,685.20	711,973,416.56
51	Засгийн газрын хувь оролцоо	630,200,685.20	711,973,416.56
51100	Засгийн газрын оруулсан капитал /Засгийн газрын сан/ орон нутгийн сан	439,167,967.50	439,167,967.50
51200	Хуримтлагдсан үр дүн	126,970,903.30	208,743,634.66
51210	Өмнөх үеийн үр дүн	177,028,762.88	126,970,903.30
51220	Тайлант үеийн үр дүн	-50,057,859.58	81,772,731.36
51300	Хөрөнгийн дахин үнэлгээний зөрүү	64,061,814.40	64,061,814.40

6	ӨР ТӨЛБӨР, ЦЭВЭР ХӨРӨНГӨ ӨМЧИЙН ДҮН VI=IV+V	630,200,685.20	725,520,281.56
---	--	-----------------------	-----------------------

2.2 Аудит хийсэн санхүүгийн үр дүнгийн тайлан

Код	Үзүүлэлт	ӨМНӨХ ОН	ТАЙЛАНТ ОН
I	ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ОРЛОГЫН ДҮН (I)	415,691,032.52	815,795,090.39
12	ТАТВАРЫН БУС ОРЛОГО	33,490,952.52	169,989,931.39
120	Нийтлэг татварын бус орлого	33,490,952.52	169,989,931.39
120017	Үнэ төлбөргүй хүлээн авсан орлого - Үндсэн хөрөнгө	12,409,000.00	17,033,320.56
120018	Үнэ төлбөргүй хүлээн авсан орлого - Бараа материал	21,081,952.52	152,956,610.83
13	ТУСЛАМЖ, САНХҮҮЖИЛТИЙН ОРЛОГО	382,200,080.00	645,805,159.00
1310	Улсын төвлөрсөн төсвөөс	329,216,000.00	385,363,500.00
131007	Тусгай зориулалтын шилжүүлгээс санхүүжих	329,216,000.00	385,363,500.00
1311	Нэмэлт санхүүжилтийн орлого	11,704,560.00	227,487,849.00
131104	Дээд шатны төсвийн захирагчийн төсөвт тусгагдсан төсвөөс доод шатны төсвийн захирагчид хуваарилсан хөрөнгө	11,704,560.00	30,832,849.00
131105	Төсвийн байгууллагын үндсэн үйл ажиллагааны хүрээнд бий болсон нэмэлт орлого	0.00	7,473,000.00
131107	Эрүүл мэндийн даатгалын сангийн нэмэлт орлого	0.00	189,182,000.00
1320	Орон нутгийн төсвөөс санхүүжих	28,678,400.00	28,725,000.00
132001	Урсгал үйл ажиллагааны санхүүжилт /орон нутгийн төсөвт байгууллага/	28,678,400.00	28,725,000.00
1340	Нийгмийн даатгалын сангийн төсвөөс санхүүжих	12,601,120.00	4,228,810.00
134002	Эрүүл мэндийн даатгалын сангаас санхүүжих	12,601,120.00	4,228,810.00
II	ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ЗАРДЛЫН ДҮН	450,126,870.47	734,022,359.03
21	УРСГАЛ ЗАРДАЛ	450,126,870.47	734,022,359.03
210	БАРАА, АЖИЛ ҮЙЛЧИЛГЭЭНИЙ ЗАРДАЛ	442,245,619.00	700,409,172.58
2101	Цалин хөлс болон нэмэгдэл урамшил	258,452,763.50	317,042,510.78
210101	Үндсэн цалин	173,357,930.41	198,523,705.46
210102	Нэмэгдэл	60,952,203.30	62,251,927.32
210103	Унаа хоолны хөнгөлөлт	4,256,004.00	4,023,796.00
210104	Урамшуулал	19,886,625.79	33,648,961.00
210105	Гэрээт ажлын хөлс	0.00	18,594,121.00
2102	Ажил олгогчоос нийгмийн даатгалд төлөх шимтгэл	32,270,310.95	42,805,161.84
210201	Тэтгэврийн даатгал	22,375,632.45	31,292,373.79
210202	Тэтгэмжийн даатгал	2,632,427.67	3,003,376.84
210203	ҮОМШӨ-ний даатгал	2,089,142.14	2,332,141.44
210204	Ажилгүйдлийн даатгал	470,282.61	554,742.41
210205	Эрүүл мэндийн даатгал	4,702,826.08	5,622,527.36
2103	Байр ашиглалттай холбоотой тогтмол зардал	27,219,000.08	10,092,563.55
210301	Гэрэл, цахилгаан	3,174,588.19	3,296,813.55
210302	Түлш, халаалт	24,044,411.89	6,795,750.00
2104	Хангамж, бараа материалын зардал	22,103,798.00	34,314,070.84
210401	Бичиг хэрэг	1,010,260.00	1,755,700.00

210402	Тээвэр, шатахуун	17,489,932.00	24,334,832.00
210403	Шуудан, холбоо, интернэтийн төлбөр	871,000.00	1,706,100.00
210405	Хог хаягдал зайлуулах, хортон мэрэгчдийн устгал, ариутгал	638,350.00	233,150.00
210406	Бага үнэтэй, түргэн элэгдэх, ахуйн эд зүйлс	1,170,140.00	3,377,203.70
210408	Бараа материал акталсны зардал	924,116.00	2,907,085.14
2105	Нормативт зардал	32,468,385.37	221,496,805.39
210501	Эм, бэлдмэл, эмнэлгийн хэрэгсэл	24,816,770.37	212,492,255.39
210502	Хоол, хүнс	7,035,115.00	8,263,550.00
210503	Нормын хувцас, зөөлөн эдлэл	616,500.00	741,000.00
2106	Эд хогшил, урсгал засварын зардал	3,682,630.00	6,580,450.00
210601	Багаж, техник, хэрэгсэл	80,000.00	0.00
210604	Урсгал засвар	3,602,630.00	6,580,450.00
2107	Томилолт, зочны зардал	1,467,400.00	1,019,057.00
210702	Дотоод албан томилолт	1,467,400.00	1,019,057.00
2108	Бусдаар гүйцэтгүүлсэн ажил, үйлчилгээний төлбөр, хураамж	1,862,454.00	2,713,666.00
210801	Бусдаар гүйцэтгүүлсэн бусад нийтлэг ажил үйлчилгээний төлбөр хураамж	0.00	1,388,000.00
210802	Аудит, баталгаажуулалт, зэрэглэл тогтоох	774,000.00	240,000.00
210803	Даатгалын үйлчилгээ	202,050.00	199,950.00
210804	Тээврийн хэрэгслийн татвар	43,500.00	47,500.00
210805	Тээврийн хэрэгслийн оношлогоо	33,000.00	33,000.00
210807	Газрын төлбөр	42,904.00	17,216.00
210808	Банк, санхүүгийн байгууллагын үйлчилгээний хураамж	247,000.00	71,600.00
210809	Улсын мэдээллийн маягт хэвлэх, бэлтгэх	520,000.00	716,400.00
2109	Бараа үйлчилгээний бусад зардал	62,718,877.10	64,344,887.18
210901	Бараа үйлчилгээний бусад зардал	3,452,000.00	1,183,996.00
210903	Үндсэн хөрөнгийн элэгдэл, хорогдол	59,266,877.10	63,160,891.18
213	УРСГАЛ ШИЛЖҮҮЛЭГ	7,881,251.47	33,613,186.45
2132	Бусад урсгал шилжүүлэг	6,216,600.00	32,671,000.00
213209	Нэг удаагийн тэтгэмж, шагнал урамшуулал	2,559,540.00	32,671,000.00
2134	Орон нутгийн төсвийн ерөнхийлөн захирагчдад олгох татаас, санхүүжилт	60,744.93	942,186.45
213403	Төвлөрүүлэх шилжүүлэг	60,744.93	942,186.45
2135	Төсвийн захирагчдаас олгосон санхүүжилт, шилжүүлэг	1,603,906.54	0.00
213503	Төвлөрүүлэх шилжүүлэг	1,603,906.54	0.00
III	ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ҮР ДҮН (III)=(I)-(II)	-34,435,837.95	81,772,731.36
V	ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ БУС ЗАРДЛЫН ДҮН	15,622,021.63	0.00
225001	Үндсэн хөрөнгө, бараа материал худалдсаны гарз	15,622,021.63	0.00
VI	ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ НИЙТ ҮР ДҮН (VI)=(III)+(IV)-(V)	-50,057,859.58	81,772,731.36

2.3 Аудит хийсэн цэвэр хөрөнгө/өмчийн өөрчлөлтийн тайлан

Код	Үзүүлэлт	Засгийн газрын оруулсан капитал	Дахин үнэлгээний нөөц	Хуримтлагдсан дүн	Засгийн газрын хувь оролцооний нийт дүн
1	2019 оны 12-р сарын 31-нээрх үлдэгдэл	439,167,967.50	64,061,814.40	177,028,762.88	680,258,544.78
2	Нягтлан бодох бүртгэлийн бодлогын өөрчлөлт	0.00	0.00	0.00	0.00
3	Дахин илэрхийлсэн үлдэгдэл	439,167,967.50	64,061,814.40	177,028,762.88	680,258,544.78
9	Тайлант үеийн үр дүн	0.00	0.00	-50,057,859.58	-50,057,859.58
10	2020 оны 12-р сарын 31-нээрх үлдэгдэл	439,167,967.50	64,061,814.40	126,970,903.30	630,200,685.20
11	2021 оны 1-р сарын 1-нээрх үлдэгдэл	439,167,967.50	64,061,814.40	126,970,903.30	630,200,685.20
13	Дахин илэрхийлсэн үлдэгдэл	439,167,967.50	64,061,814.40	126,970,903.30	630,200,685.20
19	Тайлант үеийн үр дүн	0.00	0.00	81,772,731.36	81,772,731.36
20	2021 оны 12-р сарын 31-наарх үлдэгдэл	439,167,967.50	64,061,814.40	208,743,634.66	711,973,416.56

2.4 Аудит хийсэн мөнгөн гүйлгээний тайлан

Код	Үзүүлэлт	ӨМНӨХ ОН	ТАЙЛАНТ ОН
I	ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ МӨНГӨН ОРЛОГЫН ДҮН (I)	382,200,080.00	541,938,659.00
13	ТУСЛАМЖ, САНХҮҮЖИЛТИЙН ОРЛОГО	382,200,080.00	541,938,659.00
1310	Улсын төвлөрсөн төсвөөс	329,216,000.00	385,363,500.00
131007	Тусгай зориулалтын шилжүүлгээс санхүүжих	329,216,000.00	385,363,500.00
1311	Нэмэлт санхүүжилтийн орлого	11,704,560.00	123,621,349.00
131104	Дээд шатны төсвийн захирагчийн төсөвт тусгагдсан төсвөөс доод шатны төсвийн захирагчид хуваарилсан хөрөнгө	11,704,560.00	30,832,849.00
131105	Төсвийн байгууллагын үндсэн үйл ажиллагааны хүрээнд бий болсон нэмэлт орлого	0.00	7,473,000.00
131107	Эрүүл мэндийн даатгалын сангийн нэмэлт орлого	0.00	85,315,500.00
1320	Орон нутгийн төсвөөс санхүүжих	28,678,400.00	28,725,000.00
132001	Урсгал үйл ажиллагааны санхүүжилт /орон нутгийн төсөвт байгууллага/	28,678,400.00	28,725,000.00
1340	Нийгмийн даатгалын сангийн төсвөөс санхүүжих	12,601,120.00	4,228,810.00
134002	Эрүүл мэндийн даатгалын сангаас санхүүжих	12,601,120.00	4,228,810.00
II	НИЙТ ЗАРЛАГА ба ЦЭВЭР ЗЭЭЛИЙН ДҮН	376,065,380.00	530,275,489.62
21	УРСГАЛ ЗАРДАЛ	376,065,380.00	530,275,489.62
210	БАРАА, АЖИЛ ҮЙЛЧИЛГЭЭНИЙ ЗАРДАЛ	368,184,128.53	496,662,303.17
2101	Цалин хөлс болон нэмэгдэл урамшил	258,452,763.50	317,042,510.79
210101	Үндсэн цалин	173,357,930.41	198,523,705.47
210102	Нэмэгдэл	60,952,203.30	62,251,927.32
210103	Унаа хоолны хөнгөлөлт	4,256,004.00	4,023,796.00
210104	Урамшуулал	19,886,625.79	33,648,961.00

210105	Гэрээт ажлын хөлс	0.00	18,594,121.00
2102	Ажил олгогчоос нийгмийн даатгалд төлөх шимтгэл	32,270,310.96	42,805,161.83
210201	Тэтгэврийн даатгал	22,375,632.45	31,292,373.78
210202	Тэтгэмжийн даатгал	2,632,427.67	3,003,376.84
210203	ҮОМШӨ-ний даатгал	2,089,142.14	2,332,141.44
210204	Ажилгүйдлийн даатгал	470,282.61	554,742.41
210205	Эрүүл мэндийн даатгал	4,702,826.09	5,622,527.36
2103	Байр ашиглалттай холбоотой тогтмол зардал	25,327,375.07	15,261,813.55
210301	Гэрэл, цахилгаан	3,174,588.19	3,296,813.55
210302	Түлш, халаалт	22,152,786.88	11,965,000.00
2104	Хангамж, бараа материалын зардал	21,292,900.00	29,202,982.00
210401	Бичиг хэрэг	1,136,300.00	1,377,000.00
210402	Тээвэр, шатахуун	17,451,300.00	23,284,832.00
210403	Шуудан, холбоо, интернэтийн төлбөр	871,000.00	1,706,100.00
210404	Ном, хэвлэл	0.00	100,000.00
210405	Хог хаягдал зайлуулах, хортон мэрэгчдийн устгал, ариутгал	638,350.00	233,150.00
210406	Бага үнэтэй, түргэн элэгдэх, ахуйн эд зүйлс	1,195,950.00	2,501,900.00
2105	Нормативт зардал	20,135,545.00	77,277,516.00
210501	Эм, бэлдмэл, эмнэлгийн хэрэгсэл	11,168,910.00	69,572,786.00
210502	Хоол, хүнс	7,570,635.00	6,803,730.00
210503	Нормын хувцас, зөөлөн эдлэл	1,396,000.00	901,000.00
2106	Эд хогшил, урсгал засварын зардал	4,103,280.00	10,893,700.00
210601	Багаж, техник, хэрэгсэл	813,000.00	982,700.00
210604	Урсгал засвар	3,290,280.00	9,911,000.00
2107	Томилолт, зочны зардал	1,467,400.00	1,019,057.00
210702	Дотоод албан томилолт	1,467,400.00	1,019,057.00
2108	Бусдаар гүйцэтгүүлсэн ажил, үйлчилгээний төлбөр, хураамж	1,862,454.00	1,195,666.00
210802	Аудит, баталгаажуулалт, зэрэглэл тогтоох	774,000.00	240,000.00
210803	Даатгалын үйлчилгээ	202,050.00	199,950.00
210804	Тээврийн хэрэгслийн татвар	43,500.00	47,500.00
210805	Тээврийн хэрэгслийн оношлогоо	33,000.00	33,000.00
210807	Газрын төлбөр	42,904.00	17,216.00
210808	Банк, санхүүгийн байгууллагын үйлчилгээний хураамж	247,000.00	71,600.00
210809	Улсын мэдээллийн маягт хэвлэх, бэлтгэх	520,000.00	586,400.00
2109	Бараа үйлчилгээний бусад зардал	3,272,100.00	1,963,896.00
210901	Бараа үйлчилгээний бусад зардал	3,272,100.00	1,963,896.00
213	УРСГАЛ ШИЛЖҮҮЛЭГ	7,881,251.47	33,613,186.45
2132	Бусад урсгал шилжүүлэг	6,216,600.00	32,671,000.00
213208	Хөдөө орон нутагт тогтвор суурьшилтай ажилласан албан хаагчдад төрөөс үзүүлэх дэмжлэг	3,657,060.00	0.00
213209	Нэг удаагийн тэтгэмж, шагнал урамшуулал	2,559,540.00	32,671,000.00
2134	Орон нутгийн төсвийн ерөнхийлөн захирагчдад олгох татаас, санхүүжилт	60,744.93	942,186.45
213403	Төвлөрүүлэх шилжүүлэг	60,744.93	942,186.45
2135	Төсвийн захирагчдаас олгосон санхүүжилт, шилжүүлэг	1,603,906.54	0.00
213503	Төвлөрүүлэх шилжүүлэг	1,603,906.54	0.00
III	ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ЦЭВЭР МӨНГӨН ГҮЙЛГЭЭ (III)=(I)-(II)	6,134,700.00	11,663,169.38
V	ХӨРӨНГӨ ОРУУЛАЛТЫН МӨНГӨН ЗАРДЛЫН ДҮН (V)	6,134,700.00	5,249,000.00
22	ХӨРӨНГИЙН ЗАРДАЛ	6,134,700.00	5,249,000.00
2200	Дотоод эх үүсвэрээр	6,134,700.00	5,249,000.00
225106	Биет ба биет бус хөрөнгө худалдан авсан зардал	6,134,700.00	5,249,000.00
VI	ХӨРӨНГӨ ОРУУЛАЛТЫН ЦЭВЭР МӨНГӨН ГҮЙЛГЭЭ (VI)=(IV)-(V)	-6,134,700.00	-5,249,000.00

VIII	НИЙТ ЦЭВЭР МӨНГӨН ГҮЙЛГЭЭ (VIII)=(III)+(VI)+(VII)	0.00	6,414,169.38
20	Мөнгө, түүнтэй адилтгах хөрөнгийн эцсийн үлдэгдэл	0.00	6,414,169.38

2.5 Аудит хийсэн төсвийн гүйцэтгэлийн тайлан

Код	Үзүүлэлт	Төлөвлөгөө	Төсвийн гүйцэтгэлийн тайлан	Зөрүү	Хувь
II	НИЙТ ЗАРЛАГА БА ЦЭВЭР ЗЭЭЛИЙН ДҮН	436,379,700.00	411,697,052.17	24,682,647.83	94%
21	УРСГАЛ ЗАРДАЛ	436,379,700.00	411,697,052.17	24,682,647.83	94%
210	БАРАА, АЖИЛ ҮЙЛЧИЛГЭЭНИЙ ЗАРДАЛ	433,679,700.00	409,026,052.17	24,653,647.83	94%
2101	Цалин хөлс болон нэмэгдэл урамшил	293,700,000.00	285,450,131.79	8,249,868.21	97%
210101	Үндсэн цалин	177,600,000.00	176,110,437.47	1,489,562.53	99%
210102	Нэмэгдэл	64,500,000.00	62,251,927.32	2,248,072.68	97%
210103	Унаа хоолны хөнгөлөлт	5,500,000.00	4,023,796.00	1,476,204.00	73%
210104	Урамшуулал	28,200,000.00	24,469,850.00	3,730,150.00	87%
210105	Гэрээт ажлын хөлс	17,900,000.00	18,594,121.00	-694,121.00	104%
2102	Ажил олгогчоос нийгмийн даатгалд төлөх шимтгэл	39,890,000.00	38,313,313.83	1,576,686.17	96%
210201	Тэтгэврийн даатгал	27,930,000.00	26,800,525.78	1,129,474.22	96%
210202	Тэтгэмжийн даатгал	3,140,000.00	3,003,376.84	136,623.16	96%
210203	ҮОМШӨ-ний даатгал	2,352,000.00	2,332,141.44	19,858.56	99%
210204	Ажилгүйдлийн даатгал	588,000.00	554,742.41	33,257.59	94%
210205	Эрүүл мэндийн даатгал	5,880,000.00	5,622,527.36	257,472.64	96%
2103	Байр ашиглалттай холбоотой тогтмол зардал	16,200,000.00	15,261,813.55	938,186.45	94%
210301	Гэрэл, цахилгаан	3,600,000.00	3,296,813.55	303,186.45	92%
210302	Түлш, халаалт	12,600,000.00	11,965,000.00	635,000.00	95%
2104	Хангамж, бараа материалын зардал	29,428,300.00	26,835,390.00	2,592,910.00	91%
210401	Бичиг хэрэг	1,080,000.00	1,060,000.00	20,000.00	98%
210402	Тээвэр, шатахуун	23,310,300.00	22,241,040.00	1,069,260.00	95%
210403	Шуудан, холбоо, интернэтийн төлбөр	1,877,500.00	1,656,100.00	221,400.00	88%
210404	Ном, хэвлэл	150,000.00	100,000.00	50,000.00	67%
210405	Хог хаягдал зайлуулах, хортон мэрэгчдийн устгал, ариутгал	810,500.00	233,150.00	577,350.00	29%
210406	Бага үнэтэй, түргэн элэгдэх, ахуйн эд зүйлс	2,200,000.00	1,545,100.00	654,900.00	70%
2105	Нормативт зардал	29,470,700.00	23,191,141.00	6,279,559.00	79%
210501	Эм, бэлдмэл, эмнэлгийн хэрэгсэл	20,070,700.00	16,314,411.00	3,756,289.00	81%
210502	Хоол, хүнс	6,000,000.00	5,975,730.00	24,270.00	100%
210503	Нормын хувцас, зөөлөн эдлэл	3,400,000.00	901,000.00	2,499,000.00	27%
2106	Эд хогшил, урсгал засварын зардал	18,083,900.00	16,142,700.00	1,941,200.00	89%
210601	Багаж, техник, хэрэгсэл	4,158,900.00	3,621,700.00	537,200.00	87%
210602	Тавилга	1,400,000.00	0.00	1,400,000.00	0%
210604	Урсгал засвар	12,525,000.00	12,521,000.00	4,000.00	100%
2107	Томилолт, зочны зардал	2,200,000.00	672,000.00	1,528,000.00	31%

210702	Дотоод албан томилолт	2,200,000.00	672,000.00	1,528,000.00	31%
2108	Бусдаар гүйцэтгүүлсэн ажил, үйлчилгээний төлбөр, хураамж	2,268,000.00	1,195,666.00	1,072,334.00	53%
210802	Аудит, баталгаажуулалт, зэрэглэл тогтоох	930,000.00	240,000.00	690,000.00	26%
210803	Даатгалын үйлчилгээ	235,000.00	199,950.00	35,050.00	85%
210804	Тээврийн хэрэгслийн татвар	60,000.00	47,500.00	12,500.00	79%
210805	Тээврийн хэрэгслийн оношлогоо	88,000.00	33,000.00	55,000.00	38%
210807	Газрын төлбөр	58,000.00	17,216.00	40,784.00	30%
210808	Банк, санхүүгийн байгууллагын үйлчилгээний хураамж	197,000.00	71,600.00	125,400.00	36%
210809	Улсын мэдээллийн маягт хэвлэх, бэлтгэх	700,000.00	586,400.00	113,600.00	84%
2109	Бараа үйлчилгээний бусад зардал	2,438,800.00	1,963,896.00	474,904.00	81%
210901	Бараа үйлчилгээний бусад зардал	2,438,800.00	1,963,896.00	474,904.00	81%
213	УРСГАЛ ШИЛЖҮҮЛЭГ	2,700,000.00	2,671,000.00	29,000.00	99%
2132	Бусад урсгал шилжүүлэг	2,700,000.00	2,671,000.00	29,000.00	99%
213209	Нэг удаагийн тэтгэмж, шагнал урамшуулал	2,700,000.00	2,671,000.00	29,000.00	99%
III	ЗАРДЛЫГ САНХҮҮЖҮҮЛЭХ ЭХ ҮҮСВЭР	436,379,700.00	418,317,310.00	18,062,390.00	96%
31	УЛСЫН ТӨСВӨӨС САНХҮҮЖИХ	385,363,600.00	385,363,500.00	100.00	100%
310003	Тусгай зориулалтын шилжүүлгээс санхүүжих	385,363,600.00	385,363,500.00	100.00	100%
32	ОРОН НУТГИЙН ТӨСВӨӨС САНХҮҮЖИХ	28,725,000.00	28,725,000.00	0.00	100%
320001	Орон нутгийн төсвөөс	28,725,000.00	28,725,000.00	0.00	100%
33	НИЙГМИЙН ДААТГАЛЫН САНГИЙН ТӨСВӨӨС САНХҮҮЖИХ	22,291,100.00	4,228,810.00	18,062,290.00	19%
330002	Эрүүл мэндийн даатгалын сангаас санхүүжих	22,291,100.00	4,228,810.00	18,062,290.00	19%
5	Мөнгө, түүнтэй адилтгах хөрөнгийн эцсийн үлдэгдэл	0.00	5,678,071.38	-5,678,071.38	#DIV/0!
62	АЖИЛЛАГСАДЫН ТОО	21.00	21.00	0.00	100%
620001	Удирдах ажилтан	1.00	1.00	0.00	100%
620002	Гүйцэтгэх ажилтан	16.00	16.00	0.00	100%
620003	Үйлчлэх ажилтан	4.00	4.00	0.00	100%

2.6 Аудит хийсэн нэмэлт төсвийн гүйцэтгэлийн тайлан

ЭЗА	Үзүүлэлт	Батлагдсан төлөвлөгөө	Гүйцэтгэл
2	НИЙТ ЗАРЛАГА БА ЦЭВЭР ЗЭЭЛИЙН ДҮН	-	122,885,251.0
21	УРСГАЛ ЗАРДАЛ	-	122,885,251.0
210	БАРАА, АЖИЛ ҮЙЛЧИЛГЭЭНИЙ ЗАРДАЛ	-	92,885,251.00
2101	Цалин хөлс болон нэмэгдэл урамшил	-	31,592,379.00
210101	Үндсэн цалин		22,413,268.00

210104	Урамшуулал		9,179,111.00
2102	Ажил олгогчоос нийгмийн даатгалд төлөх шимтгэл	-	4,491,848.00
210201	Тэтгэврийн даатгал		4,491,848.00
2104	Хангамж, бараа материалын зардал	-	2,367,592.00
210401	Бичиг хэрэг		317,000.00
210402	Тээвэр, шатахуун		1,043,792.00
210403	Шуудан, холбоо, интернэтийн төлбөр		50,000.00
210406	Бага үнэтэй, түргэн элэгдэх, ахуйн эд зүйлс		956,800.00
2105	Нормативт зардал	-	54,086,375.00
210501	Эм, бэлдмэл, эмнэлгийн хэрэгсэл		53,258,375.00
210502	Хоол, хүнс		828,000.00
2107	Томилолт, зочны зардал	-	347,057.00
210702	Дотоод албан томилолт		347,057.00
213	УРСГАЛ ШИЛЖҮҮЛЭГ	-	30,000,000.00
2132	Бусад урсгал шилжүүлэг	-	30,000,000.00
213209	Нэг удаагийн тэтгэмж, шагнал урамшуулал		30,000,000.00
	ЗАРДЛЫГ САНХҮҮЖҮҮЛЭХ ЭХ ҮҮСВЭР	-	123,621,349.0
1311	Нэмэлт санхүүжилтийн орлого	-	123,621,349.00
131104	Дээд шатны төсвийн захирагчийн төсөвт тусгагдсан төсвөөс доод шатны төсвийн захирагчид хуваарилсан хөрөнгө	-	30,832,849.00
131105	Төсвийн байгууллагын үндсэн үйл ажиллагааны хүрээнд бий болсон нэмэлт орлого	-	7,473,000.00
131107	Эрүүл мэндийн даатгалын сангийн нэмэлт орлого	-	85,315,500.00
5	Мөнгө, түүнтэй адилтгах хөрөнгийн эцсийн үлдэгдэл	-	736,098.00

3. Аудитын тайлан

3.1 Ерөнхий зүйл

Төрийн аудитын тухай хуулийн 20 дугаар зүйлийн 20.1-д “Төрийн аудитын байгууллага аудитын дүнд үндэслэн дүгнэлт, зөвлөмж бүхий аудитын тайлан гаргана.” гэж заасны дагуу Говь-Алтай аймгийн Эрдэнэ сумын Эрүүл мэндийн төвийн 2021 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөрх санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлд хийсэн санхүүгийн тайлангийн аудитын тайланг танилцуулж байна.

Аудитын тайланд шалгагдагч этгээд, түүний орчин, аудитад хамааралтай дотоод хяналт, нягтлан бодох бүртгэл, холбогдох санхүүгийн тайлагналын үзэл баримтлалын талаар болон аудитын явцад илрүүлсэн алдаа, зөрчил, гаргасан шийдэл, анхаарал татахуйц бусад чухал асуудал болон аудитын санал дүгнэлт, түүний үндэслэлийг хураангуйлан толилуулав.

Энэхүү тайланд шалгагдагч этгээдэд нягтлан бодох бүртгэлийн үйл ажиллагаатай холбоотой өгсөн зөвлөмжийг тусгасан болно.

Аудитыг Говь-Алтай аймаг дахь Төрийн аудитын газрын аудитор Б.Цэвэлмаа гүйцэтгэж, хяналтыг ахлах аудитор Ж.Бүжинханд, аудитын менежер Д.Эрдэнэчимэг, газрын дарга, тэргүүлэх аудитор Х.Түвшинбаяр нар тус тус хэрэгжүүлсэн.

Говь-Алтай аймгийн Эрдэнэ сумын Эрүүл мэндийн төвийн 2021 оны санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлийг Говь-Алтай аймаг дахь Төрийн аудитын газарт 2022 оны 01 дүгээр сарын 24-ний өдрийн 02 дугаар албан бичгээр ирүүлсэн байна.

3.2 Байгууллага, түүний орчин ба дотоод хяналт

Говь-Алтай аймгийн Эрдэнэ сумын Эрүүл мэндийн төв нь үйлчлүүлэгчдэд ээлтэй сэтгэлд хүрсэн эмнэлгийн болон нийгмийн эрүүл мэндийн тусламжийг жигд хүртээмжтэй хүргэх чиг үүрэгтэй Эрдэнэ сумын төсвийн төвлөрүүлэн захирагчийн харьяа байгууллага юм.

Тайлант хугацаанд байгууллагын үйл ажиллагаа, санхүү, нягтлан бодох бүртгэлд мөрддөг хууль тогтоомж болон бодлого чиглэлд өөрчлөлт ороогүй байна.

Байгууллагын удирдлагын хэрэгжүүлж байгаа дотоод хяналтуудаас төлөвлөлтийн үе шатанд аудитад хамааралтай хяналтыг авч үзэж, гүйцэтгэх үе шатанд хяналтын сорил гүйцэтгэсний үр дүнд дотоод хяналтын үйл ажиллагааны зохион байгуулалт, хэрэгжилт үр нөлөөтэй байна.

Тус байгууллагын мөрдөж байгаа Нягтлан бодох бүртгэлийн бодлогын баримт бичиг нь холбогдох хууль тогтоомж, нягтлан бодох бүртгэлийн стандартад нийцсэн, тус байгууллагын үйл ажиллагааны онцлогт тохирсон байна.

Дотоод аудитын чиг үүрэг, түүний гүйцэтгэсэн ажлын найдвартай байдлын талаар ойлголт олж авснаар дотоод аудитын гүйцэтгэсэн ажлыг аудитад ашиглах, дотоод аудитораас шууд тусалцаа авах шаардлагагүй гэж үзлээ.

3.3 Санхүүгийн тайлагналын үзэл баримтлал

Санхүүгийн тайланг бүх материаллаг зүйлсийн хувьд холбогдох санхүүгийн тайлагналын үзэл баримтлалын дагуу бэлтгэсэн эсэх талаар аудитор санал дүгнэлтээ илэрхийлснээр санхүүгийн тайлангийн зорилтот хэрэглэгчдийн зүгээс үзүүлэх итгэл үнэмшлийн хэмжээг нэмэгдүүлэхэд санхүүгийн тайлангийн аудитын зорилго оршино.

Говь-Алтай аймгийн Эрдэнэ сумын Эрүүл мэндийн төвийн 2021 оны санхүүгийн тайлан дахь ажил гүйлгээг аккруэл сууриар хөтөлж, нийтлэг зорилготой, үнэн зөв толилуулгын үзэл баримтлалын дагуу бэлтгэсэн хүлээн зөвшөөрөхүйц санхүүгийн тайлагналын үзэл баримтлал гэж үнэлсэн.

3.4 Материаллаг байдал

Төлөвлөлтийн болон гүйцэтгэлийн материаллаг байдлыг АДБОУС 2320 дагуу тодорхойлсон бөгөөд материаллаг байдлын суурь үзүүлэлтээр санхүүгийн үр дүнгийн тайлангийн нийт зардлыг сонгож, материаллаг буруу илэрхийллийн эрсдэл бага гэж үнэлэн материаллаг байдлын түвшнийг 2 хувиар тогтоов.

Төлөвлөлтийн материаллаг байдлыг 2020 оны санхүүгийн үр дүнгийн тайлангийн нийт зардал 450.0 сая төгрөгөөс 2 хувиар буюу 9.0 сая төгрөгөөр, гүйцэтгэлийн материаллаг байдлыг төлөвлөлтийн материаллаг байдлын 80 хувиар буюу 7.2 сая төгрөгөөр тогтоосон.

Аудитын эрсдэл бага гэж үзэж тогтоосон төлөвлөлтийн ерөнхий материаллаг байдлыг АДБОУС 2320-н 13-д заасны дагуу аудитын явцад дахин хянаж шинэчлэн тогтоох шаардлагагүй гэж үзлээ.

3.5 Санхүүгийн тайлангийн тодруулга

Говь-Алтай аймгийн Эрдэнэ сумын Эрүүл мэндийн төвийн 2021 оны жилийн эцсийн санхүүгийн байдлын тайлангаарх нийт хөрөнгийн дүн өмнөх оноос 15.1 хувиар буюу 95.3 сая төгрөгөөр өссөн байна. Өмнөх оны үзүүлэлтээс материаллаг өөрчлөлт гарсан авлага, бараа материалын данс байна.

Бараа материалын дансны үлдэгдэл 51.4 сая төгрөг болж 25.9 сая төгрөгөөр өссөн нь тайлант онд төсвийн хөрөнгөөр 144.0 сая төгрөгийн хөрөнгө бэлтгэж, үнэ төлбөргүй 153.0 сая төгрөгийн эм боох материал, хангамжийн материал хүлээн авч, үйл ажиллагаандаа 268.2 сая төгрөгийн материалыг зарцуулж, 2.9 сая төгрөгийн материалыг акталж данснаас хассантай холбоотой.

Үндсэн хөрөнгө дансны үлдэгдэл 836.9 сая төгрөг болж 18.9 сая төгрөгөөр өссөн нь төсвийн хөрөнгөөр 5.2 сая төгрөгийн хөрөнгө бэлтгэж, 17.0 сая төгрөгийн хөрөнгийг үнэ төлбөргүй хүлээн авч, 3.4 сая төгрөгийн хөрөнгийн акталж данснаас хассантай холбоотой байна.

Засгийн газрын оролцоо дансны үлдэгдэл 712.0 сая төгрөг болж 81.8 сая төгрөгөөр өссөн нь тайлант үеийн үр дүнгээс шалтгаалжээ. Орлого өмнөх оноос 96.3 хувиар буюу 400.1 сая төгрөгөөр өссөн нь үнэ төлбөргүй хүлээн авсан хөрөнгийн орлого, урсгал үйл ажиллагааны санхүүжилтийн орлого, нэмэлт санхүүжилтийн орлого өссөнтэй холбоотой байна.

Өмчийн өөрчлөлтийн тайлангаар өмнөх оны үр дүн рүү хаасан бичилт хийгдээгүй ба тайлант оны хуримтлагдсан үр дүнгийн эцсийн үлдэгдэл 272.8 сая төгрөг болсон байна.

3.6 Төсвийн төлөвлөлт, гүйцэтгэл, нэмэлт төсөв

Төсвийн тухай хуулийн 6 дугаар зүйлийн 6.1-д заасны дагуу төсвийг төлөвлөх, хэрэгжүүлэх, тайлагнахад эрх бүхий байгууллага, төсвийн захирагч нь тус хуулийн 5 дугаар зүйлийн 5.1-д заасан төсвийн зарчмыг мөрдлөг болгож, хэрэгжүүлэх үүрэгтэй.

3.6.1 Төсвийн төлөвлөлт

Тус байгууллагын 2021 оны төсвийн төсөлд урсгал зардлыг санхүүжүүлэх эх үүсвэрийг 509.8 сая төгрөгөөр тооцон төлөвлөж, дээд шатны төсвийн захирагчид хүргүүлсэн байна.

Төсөв захирагчид хүргүүлсэн төсвийн төслөөс 73.4 сая төгрөгөөр бууруулж, 436.4 сая төгрөгөөр баталжээ. Төсвийн төсөл өмнөх оны батлагдсан төсвөөс их байгаа нь цалин хөлс болон нэмэгдэл урамшлын зардал, хангамж, бараа материалын зардал, нормативт зардал, бусдаар гүйцэтгүүлсэн ажил үйлчилгээний төлбөр хураамжийн зардлыг бууруулж баталсантай холбоотой байна.

3.6.2 Төсвийн гүйцэтгэл

Тайлант онд төсөв захирагчийн 2 хөтөлбөрийн хүрээнд 4 арга хэмжээг тусгай зориулалтын шилжүүлэг, орон нутгийн төсвөөс санхүүжүүлэхээр 436.4 сая төгрөгийн төсөв баталсан байна.

Гүйцэтгэлээр тусгай зориулалтын шилжүүлгээс 385.4 сая төгрөгийн, орон нутгийн төсвөөс 28.7 сая төгрөгийн, эрүүл мэндийн даатгалын сангаас 4.2 сая төгрөгийн санхүүжилт авч, урсгал үйл ажиллагаанд 411.7 сая төгрөгийг зарцуулж, 0.9 сая төгрөгийг орон нутгийн төсөвт төвлөрүүлж, 5.7 сая төгрөгийн мөнгө, түүнтэй адилтгах хөрөнгийн эцсийн үлдэгдэлтэй байна.

Төсвийн нийт зардлын гүйцэтгэл 411.7 сая төгрөг буюу 94 хувьтай байгаа нь цалин хөлс болон нэмэгдэл урамшлын зардлыг 8.2 сая төгрөгөөр, ажил олгогчоос нийгмийн даатгалд төлөх шимтгэлийг 1.6 сая төгрөгөөр, байр ашиглалттай холбоотой тогтмол зардлыг 0.9 сая төгрөгөөр, хангамж, бараа материалын зардлыг 2.6 сая төгрөгөөр, нормативт зардлыг 6.3 сая төгрөгөөр, томилолт, зочны зардлыг 1.5 сая төгрөгөөр, бусдаар гүйцэтгүүлсэн ажил, үйлчилгээний төлбөр хураамжийн зардлыг 1.0 сая төгрөгөөр тус тус хэмнэж зарцуулсантай холбоотой байна.

Батлагдсан төсөв, гүйцэтгэл, түүний хэтрэлт, хэмнэлтийг орлого, зардлын зүйл тус бүрээр харуулсан мэдээллийг энэ тайлангийн 2.5-д харуулав.

3.6.3 Нэмэлт төсөв

Төсвийн тухай хуулийн 47 дугаар зүйлийн 47.2-т “нэмэлт төсөв, түүнтэй холбогдсон үйл ажиллагаа нь төсвийн нэгэн адил санхүүгийн болон төсвийн гүйцэтгэлийн тайлангийн бүрэлдэхүүн хэсэг байна” гэж заасны дагуу байгууллага нэмэлт санхүүжилтийн тайлан гаргах үүрэгтэй.

Нэмэлт санхүүжилтийн дансаар дээд шатны төсөв захирагчаас 30.8 сая төгрөгийн, эрүүл мэндийн даатгалын сангаас 85.3 сая төгрөгийн санхүүжилт авч, 7.5 сая төгрөгийн нэмэлт орлого олж, 122.9 сая төгрөгийг урсгал үйл ажиллагаанд зарцуулж, 0.7 сая төгрөгийн мөнгөн хөрөнгийн үлдэгдэлтэй байна.

Нэмэлт төсвийн тайланг орлого, зардлын зүйл тус бүрээр энэ тайлангийн 2.6-д харуулав.

3.7 Асуудлыг онцолсон хэсэг ба бусад асуудлын хэсэг

Тодорхойлсон тодорхой бус байдал үүссэн, хэрэглэгчдэд хамааралтай санхүүгийн тайланд толилуулаагүй, тодруулаагүй асуудалгүй болно.

3.8 Аудитын гол асуудал

Тодорхойлсон тайлант үеийн санхүүгийн тайлангийн аудитад үлэмж нөлөө үзүүлэх асуудлууд байхгүй болно.

3.9 Санхүүгийн тайлангийн аудитаар шалгасан нийцлийн аудитын асуудал

Нийцлийн аудитыг санхүүгийн тайлангийн аудиттай хослуулан хийх тохиолдолд аудитор аль стандартыг дагаж мөрдөхийг үнэлэх, нийцлийн асуудлын талаарх дүгнэлтийг санхүүгийн тайлангийн аудитын санал дүгнэлтээс тусад нь салгах ёстой гэж заасны дагуу тус байгууллагын 2021 оны Шилэн дансны хуулийн хэрэгжилт, худалдан авалтын и-баримтын бүрдүүлэлт, тайлагналыг хяналаа.

3.9.1 Шилэн дансны тухай хуулийн хэрэгжилт

Шилэн дансны тухай хуулийн 6 дугаар зүйл, Засгийн газрын 2016 оны 29 дүгээр тогтоолоор баталсан “Шилэн дансны цахим хуудсанд тавих мэдээллийн агуулга, нийтлэг стандартыг тогтоох журам”-ын заалтыг хэрэгжүүлэх зорилгоор www.shilendans.gov.mn цахим хуудсанд холбогдох мэдээллийг оруулсан байх үүрэгтэй.

Тайлант хугацаанд Шилэн дансны цахим хуудсанд оруулбал зохих 169 мэдээллээс 167 мэдээллийг хугацаандаа мэдээлсэн, 2 мэдээллийг хугацаа хоцорч мэдээлсэн байна.

Нийцсэн бөгөөд зохистой байх батламж мэдэгдлийн түвшинд хэрэгжүүлсэн горим, сорилд үндэслэн шилэн дансанд байршуулсан мэдээлэл нь шилэн дансны тухай хуулийн 6 дугаар зүйл “Энэ хуулийн 3.1.1, 3.1.2-т заасан байгууллага дараах мэдээллийг долоо хоногийн дотор мэдээлнэ”, “6.4.4. таван сая төгрөгөөс дээш үнийн дүн бүхий худалдан авсан бараа, ажил үйлчилгээний нэр, санхүүжилтийн хэмжээ, нийлүүлэгчийн нэр, хаяг”, “6.4.5. цалингийн зардлаас бусад таван сая төгрөгөөс дээш үнийн дүн бүхий орлого, зарлагын мөнгөн гүйлгээг гүйлгээ тус бүрээр, гүйлгээний агуулга, хүлээн авагчийн нэр” гэсэн холбогдох заалттай нийцсэн байна гэж дүгнэлээ.

3.9.2 Нэмэгдсэн өртгийн албан татварын тухай хуулийн хэрэгжилт

Тайлант онд 10.5 сая төгрөгийн худалдан авалтын и-баримтыг дутуу шивүүлснийг аудитын явцад залруулсан.

Нийцсэн бөгөөд зохистой байх батламж мэдэгдлийн түвшинд хэрэгжүүлсэн горим, сорилд үндэслэн Нягтлан бодох бүртгэлийн тухай хуулийн 13.7, Татварын ерөнхий хуулийн 28., 2-т " Нэмэгдсэн өртгийн албан татварын тухай хуулийн 14.3 дахь заалттай нийцсэн байна гэж дүгнэлээ.

3.10 Өмнөх зөвлөмжийн хэрэгжилт

Өмнөх оны санхүүгийн тайлангийн аудитаар өгсөн 0.5 сая төгрөгийн төлбөрийн актыг барагдуулж, 17.8 сая төгрөгийн зөрчил арилгах албан шаардлага, 19.1 сая төгрөгийн зөвлөмжийн хэрэгжилтийг хангуулсан байна. "Төрөөс эмийн талаар баримтлах бодлогын хэрэгжилт, үр нөлөө" гүйцэтгэлийн аудитаар 4 зөрчил арилгах албан шаардлага, 5 зөвлөмж хүргүүлсэн, шийдвэрийн хэрэгжилтийг ирүүлэх хугацаа болоогүй байна.

3.11 ДАРААГИЙН АУДИТААР АНХААРАХ АСУУДАЛ

Дараагийн аудитаар эд хөрөнгийн тооллого, эм, боох материалын үлдэгдэл эмийн санчийн тайлантай нэр төрөл, нэг бүрийн үнэ, тоо ширхгээрээ таарч байгаа эсэхийг үзэх нь зүйтэй. Мөн эрүүл мэндийн даатгалын сангийн дутуу санхүүжилттэй холбоотой үүссэн өглөг, авлагын барагдуулалтыг тулган баталгаажуулах нь зүйтэй.

4. Аудитын илрүүлэлт

Аудитаар нийт 15.4 сая төгрөгийн алдаа зөрчил илэрснээс 14.4 сая төгрөгийн алдааг залруулж, 1.0 сая төгрөгийн зөрчилд албан шаардлага өгсөн.

4.1 Залруулсан алдаа

Бараа материалын тодруулга тайланг 0.9 сая төгрөгөөр, санхүүгийн үр дүнгийн тайланг 0.3 сая төгрөгөөр зөрүүтэй тайлагнасныг аудитын явцад байгууллагын удирдлага, нягтлан бодогч хүлээн зөвшөөрч санхүүгийн тайланд залруулав. Нэмэлт санхүүжилтийн төсвийн хэлбэлзэл 2.7 сая төгрөгөөр зөрүүтэй байсныг аймгийн Төрийн санд хандаж засварлуулахаар тохиролцов. Зардлыг түүвэрлэн үзэхэд 10.5 сая төгрөгийн и-баримтгүй худалдан авалт хийсэн байсныг аудитын явцад нөхөж шивүүлсэн.

4.2 Төлбөрийн акт

Төлбөрийн акт тогтоосон алдаа, зөрчилтэй асуудал байхгүй.

4.3 Албан шаардлага

Хугацаа дууссан үндэслэлээр 0.9 сая төгрөгийн эмийг акталж устгасан нь Төрийн болон орон нутгийн өмчийн тухай хуулийн 67 дугаар зүйлийн 67.1-т "Төрийн өмчит хуулийн этгээдийн эрх баригч нь өмч хөрөнгийн хадгалалт, хамгаалалтын байдалд өдөр тутам тавих дотоодын хяналтыг зохион байгуулж, түүний үр дүнг төрийн өмнө хариуцна", 31 дүгээр зүйлийн 31.3.1-т "Худалдах, шилжүүлэх, устгах эд хөрөнгийн талаар өмч хамгаалах Байнгын зөвлөл дүгнэлт гаргасан байх"; гэж заасныг зөрчсөн, нийцсэн бөгөөд зохистой байх батламж мэдэгдлийг хангахгүй байгаа тул албан шаардлага хүргүүлээ.

Татварын тодорхойлолтоор 0.05 сая төгрөгийн илүү, 0.01 сая төгрөгийн дутуу төлөлт татварын цахим системд бүртгэлтэй байгаа нь Нягтлан бодох бүртгэлийн тухай хуулийн 14 дүгээр зүйлийн 14.4-т "Нягтлан бодох бүртгэлд дараах зүйлсийг заавал бүртгэнэ", 14.4.1-т "Аж ахуйн бүх ажил, гүйлгээ", 14.4.2-т "Бүх хөрөнгө, хөрөнгө оруулалт, авлага", 14.4.3-т "Бүх өр төлбөр" гэж заасныг зөрчсөн, нийцсэн бөгөөд зохистой байх батламж мэдэгдлийг хангахгүй байгаа тул албан шаардлага хүргүүлээ.

Эм боох материалын үлдэгдлээс 10 нэр төрлийн эмийг сонгон тоо хэмжээ, нэг бүрийн үнээр нь тулгахад 2 нэр төрлийн эм нярвын тайлангийн үлдэгдлээс зөрүүтэй байгаа нь Нягтлан бодох бүртгэлийн тухай хуулийн 13 дугаар зүйлийн 13.5-т "Анхан шатны баримтад түүнийг үйлдсэн, зөвшөөрсөн буюу шалгасан ажилтан гарын үсэг зурж, тамга, тэмдэг дарснаар уг баримт хүчин төгөлдөр болно. Цахим хэлбэрээр бүрдүүлсэн анхан шатны баримт нь цахим гарын үсгээр баталгаажсан байна", 13.6-д "Анхан шатны баримтын үнэн зөвийг түүнийг үйлдсэн, зөвшөөрсөн, шалгаж хүлээн авсан ажилтан хариуцна" гэж заасныг зөрчсөн, оршин байх батламж мэдэгдлийг хангахгүй байгаа тул албан шаардлага хүргүүлээ.

4.4 Зөвлөмж

Зөвлөмж өгөх алдаа зөрчилтэй асуудал байхгүй.

Аудитын явцад бидэнтэй хамтран ажилласан холбогдох ажилтнуудад талархал илэрхийлье.

5. Аудитаар илэрсэн алдаа, зөрчлийн нэгтгэл

/сая төгрөгөөр/

д/д	Аудитад хамрагдсан байгууллагын нэр	Нийт алдаа, зөрчлийн		Үүнээс							
				Залруулга		Төлбөрийн акт		Албан шаардлага		Зөвлөмж	
		Тоо	Дүн	Тоо	Дүн	Тоо	Дүн	Тоо	Дүн	Тоо	Дүн
1	Говь-Алтай аймгийн Эрдэнэ сумын Эрүүл мэндийн төв	5	15.4	2	14.4	0	0	3	1.0	0	0